



**ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 14

Мандалговь

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.1 д, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 17.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

*Дундговь аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12
дугаар сарын 28 – ны өдрийн 14 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт*

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

МАНДАЛГОВЬ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.” гэсэн заалтыг үндэслэж, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсрууллаа.

Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”, салбарын хөгжлийн зорилтот хөтөлбөр, Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан боловсруулахаас гадна Дундговь аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсруулсан.

Энэхүү бодлогын баримт бичиг нь хөгжлийн тэргүүлэх 6 бүлгийг хамарч байна. Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 бүлэг 19 чиглэл /салбар/-ийн хүрээнд 15 зорилго, 46 зорилт, 226 арга хэмжээг төлөвлөн гаргалаа.

АГУУЛГА

НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

- 1.1 Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1 Эрүүл мэнд
- 2.2 Биеийн тамир, спорт
- 2.3 Боловсрол
- 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- 2.5 Үндэсний бахархал, өв соёл

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 3.1 Санхүү, төсвийн зохицуулалт
- 3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр
- 3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
- 3.4 Аялал жуулчлал
- 3.5 Эрчим хүч
- 3.6 Тээвэр, логистик

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ
- 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба
- 4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм
- 4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого
- 4.5 Батлан хамгаалах

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Ногоон хөгжил

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилго:

- Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.

Зорилт: 1.1

- Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 1.1.1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- 1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах.
- 1.1.3. Нэгдсэн эмнэлгийг коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах.
- 1.1.4. Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах.
- 1.1.5. Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх.
- 1.1.6. Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах.
- 1.1.7. Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт, арга хэмжээнд хамруулах.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго:

- Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувьд хүргэнэ.

2.1 Эрүүл мэнд

Зорилго:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ.

Зорилт: 2.1.1

- Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 онд 67.4 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулах.
- 2.1.1.2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх.
- 2.1.1.3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах.
- 2.1.1.4. Өвөр Монголын өөртөө засах орны уламжлалтын эмчилгээ, оношилгооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах.
- 2.1.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх.

Зорилт: 2.1.2

- Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9-д хүргэж бууруулна.

Арга хэмжээ:

- 2.1.2.1. Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах.
- 2.1.2.2 Сумдад 0-5 насны хоол тэжээлийн архаг дутагдалтай хүүхдийн сувилал ажиллуулах.

Зорилт: 2.1.3

- Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.1.3.1. Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологиор хангана.
- 2.1.3.2. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх.
- 2.1.3.3. Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах.
- 2.1.3.4. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох
- 2.1.3.5. Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах.

Дэд зорилт: 2.1.3.1.

- Эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85 хувь байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.1.3.1.1. Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих.
- 2.1.3.1.2. Нэгдсэн эмнэлгийн амбулатори, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар, Боржигон мандал, Өлзийт мандал өрхийн эмнэлэг, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийх.
- 2.1.3.1.3. Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах.
- 2.1.3.1.4. Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх.

Зорилт: 2.1.4

- Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 онд 97.5 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 2.1.4.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах.

2.1.4.2. Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх.

2.1.4.2.1. Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж, орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх.

2.1.4.2.2. “Ахмадын ордон”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-д ахмад настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх.

2.1.4.3. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, сургалтад хамруулах.

2.2 Биеийн тамир, спорт

Зорилго:

- Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 1835-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай байсныг 2024 онд 33.9 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.2.1.

- Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2024 онд 28105-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.2.1.1. Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх.

2.2.1.1.1. Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх.

2.2.1.1.2. Монгол улсын гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөрийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах.

2.2.1.1.3. "Бага олимп" наадмыг 2 жил тутамд зохион байгуулах.

2.2.1.1.4. Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион байгуулах.

2.2.1.1.5. Сагсан бөмбөгийн 3x3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлэх.

2.2.1.2. Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг

байгуулах.

2.2.1.3. Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах.

2.3 Боловсрол

Зорилго:

- Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.3.1

- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2024 онд 76 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.3.1.1. Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр цэцэрлэгийн барилга барих.

2.3.1.2. 1-2 настай хүүхдийг яслийн бүлэг, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулах.

2.3.1.3. Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургах.

2.3.1.4. СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

Зорилт: 2.3.2

- ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь байсныг 2024 онд 96.5 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.3.2.1. Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт суманд шинээр сургуулийн барилга барих.

2.3.2.1.1. Сайнцагаан сумын ЕБС-ийг түшиглэн олон улсын жишигт нийцсэн ЕБС-ийг байгуулах.

2.3.2.1.2. Хулд сумын ЕБС-ийн барилгын их засварын ажлыг хийх

2.3.2.2. Сайнцагаан, Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Эрдэнэдалай суманд шинээр дотуур байрын барилга барих.

2.3.2.3. Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх.

2.3.2.3.1. Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх.

2.3.2.4. Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулах.

2.3.2.4.1. Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь

зөвлөх багийн үйлчилгээнд хамруулах.

2.3.2.5. Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.3.2.5.1. СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоодод туршлага судлуулах.

2.3.2.5.2. ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

2.3.2.6. Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах.

2.3.2.7. Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах.

2.3.2.8. Сургууль бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах.

2.3.2.9. Сургууль, дотуур байрыг 100 хувь шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох.

2.3.2.10. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах.

Зорилт: 2.3.3

- МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.3.3.1. Байгууллагын магадлан итгэмжлэлд орох.

2.3.3.2. Багшлах бүрэлдэхүүний боловсролын зэргийг ахиулан магистрын сургалтад хамруулах.

2.3.3.3. Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг барилга болон хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр боловсруулж, дүгнэлт гаргуулах.

2.3.3.4. Хөдөө аж ахуйн мэргэжлийн кабинетыг байгуулах.

2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Зорилго:

- Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 74.8 хувь байсныг 2024 онд 77.2 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.4.1

- Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2024 онд 12218-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.1.1. Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.

2.4.1.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлэх.

Зорилт: 2.4.2

- 2019 оны байдлаар ажиллаж байгаа 22040 иргэний байнгын ажлын байрыг 460-аар нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

2.4.2.1. Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж 2024 онд 125 ажлын шинэ байр бий болгох.

2.4.2.2. Бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранд 155 иргэнийг нэмж зуучилах.

2.4.2.3. Хөдөлмөр эрхлэх төсөлд 180 иргэнийг нэмж хамруулан, байнгын ажлын байртай болгох.

Дэд зорилт: 2.4.2.1

- Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэний байнгын ажлын байр 2020 онд 14 хувь байсныг 2024 онд 34 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.2.1.1. 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулах.

2.4.2.1.2. 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийн жил бүр 20 хувийг нь мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах.

2.4.2.1.3. Жил бүр мэргэжил эзэмшүүлэх сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 10 хувийг хөтөлбөр төсөлд хамруулах.

2.4.2.1.4. 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах.

2.4.2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг шинээр барьж ашиглалтад оруулах.

Зорилт: 2.4.3

- Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага 2019 онд 24 байсныг 2024 онд 36-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.3.1. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ,

оношилгоонд тогтмол хамруулах.

2.4.3.2. Ахмад настнуудыг нас, бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах.

2.4.3.3. Аймгийн ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах.

2.4.3.4. Аймгийн ахмадын байгууллагын түүхийн ном хэвлүүлэх.

Зорилт: 2.4.4

- Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2019 онд 85 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.4.1. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулах.

2.4.4.2. “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд дээвэр, халуун ус, ариун цэврийн шинэ байгууламж, сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах.

2.4.4.3. Хүүхдийн паркийг стандартын дагуу орчин үеийн тоглоомтой болгох.

2.4.4.4. Хүүхдийн паркийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл шинээр хийх.

Зорилт: 2.4.5

- Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын дундаж хувь 2019 онд 22.3 байсныг 2024 онд 45 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.5.1. Залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх.

2.4.5.2. Залуучуудын хөгжлийн цогцолборыг шинээр байгуулах.

2.5 Үндэсний бахархал, өв соёл

Зорилго:

- Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд 294454 байсныг 2024 онд 37120-оор нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.5.1

- Соёл, урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийн тоо 2020 онд 14 байгааг 2024 онд 64.2 хувиар бууруулна.

Арга хэмжээ:

2.5.1.1. Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах.

2.5.1.2. Аймгийн Музейн барилгын зураг төсвийг хийлгэж, барилгыг барьж ашиглалтад оруулах.

2.5.1.3. Хүүхдийн театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах.

2.5.1.4. "Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах.

2.5.1.5. Аймгийн Төв Номын сангийн барилгын дээврийн засвар, Сайхан-Овоо сумын Соёлын төвийн барилгад их засвар хийх.

Зорилт: 2.5.2

- Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 60 байгааг 2024 онд 78.8 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.2.1. Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх.

2.5.2.2. Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулах.

Зорилт: 2.5.3

- Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 1431 байсныг 2024 онд 2587-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.3.1. Үндэсний бахархлыг шингээсэн шинэ уран бүтээлүүд туурвих.

2.5.3.2. Цэргийн ангийг түшиглэн "Үлээвэр хөгжмийн хамтлаг" байгуулах.

2.5.3.3. "Уяхан замбуу тивийн наран" уртын дуучид, морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулах.

2.5.3.4. Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах.

2.5.3.4.1. Уран үгсийн чуулган яруу найргийн наадам зохион байгуулах.

2.5.3.5. Адаацаг сумын Сүм хөх бүрдэд байгалийн түүхийн музей байгуулах

2.5.3.5.1. Музейн сан хөмрөгийг насжилт өндөртэй эртний үзмэрүүдээр баяжуулах.

2.5.3.6. Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох.

2.5.3.7. Төвд номын фондыг шинээр үүсгэн байгуулах.

2.5.3.8. "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг түшиглэн "Ардын зан үйл- амьдрах арга ухаан" хөтөлбөрт сургалтыг зохион байгуулах.

2.5.3.9. Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулах.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Зорилго:

- Аймгийн ДНБ 2019 онд 383383.01 сая төгрөг байгааг 2024 онд 513134.61 сая төгрөгт хүргэнэ.

3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго: 3.1.

- Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 7697110.4 мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж, 2024 онд 8331600.0 мянган төгрөгт хүргэнэ.

Зорилт: 3.1.1

- Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт 2020 онд 93.9 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.1.1.Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлэх.

3.1.1.2. Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь биелүүлэх.

Зорилт: 3.1.2.

- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.2.1. Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх.

3.1.2.2.Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах.

3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр

Зорилт: 3.2.1

- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2019 онд 647.5 сая төгрөг байгааг 2024 онд 2,648.0 сая төгрөгт хүргэнэ.

Арга хэмжээ:

3.2.1.1.Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ 2020 онд 2 байсныг 2024 онд 18 болгон нэмэгдүүлэх.

3.2.1.2.Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд

тавьж шийдвэрлүүлэх.

3.2.1.3. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, "Дундговь аймгийн хөгжлийг дэмжих сан" байгуулах.

3.2.1.4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах.

3.2.1.5. Дэлгэрхангай сумын Тарагтын гөлтгөнийн уурхайг түшиглэн гипсэн хавтангийн үйлдвэр байгуулах.

3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Зорилго:

- 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2024 онд 56-аас доошгүй хувьд хүргэнэ.

Зорилт: 3.3.1.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 221,279.85 сая төгрөг байсныг 2024 онд 294,221.45 сая.төгрөгт хүргэнэ.

Арга хэмжээ:

3.3.1.1. Дундговийн мах арга хэмжээг хэрэгжүүлж сумдад мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр байгуулах.

3.3.1.2. Хүн амын өвөл, хавар, зуны хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлж махны хангамж, үнийн тогтвортой байдлыг хангах.

3.3.1.3. "Дундговь үйлдвэрлэл" арга хэмжээг хэрэгжүүлж орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх хоршоодыг сум бүрт байгуулах.

3.3.1.4. Эдийн засгийн үр ашиг бүхий ажлын байр шинээр бий болгох инновацид суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих.

3.3.1.5. Барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтыг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.

3.3.1.6. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч малчин өрхийн тоог нэмэгдүүлэх.

3.3.1.7. Ноос, ноолуур, арьс ширний анхан шатны үйлдвэр, цехийг байгуулах.

3.3.1.8. Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амыг жилийн турш шинэ ургацын нарийн ногоогоор тасралтгүй хангах.

3.3.1.9. Сайнцагаан суманд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж хүн амын хүнсний нарийн ногооны хэрэгцээг тасралтгүй хангах.

3.3.1.10. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах.

3.3.1.11. Өлзийт суманд ингэний фермерийн аж ахуйг байгуулж, сүүг үйлдвэр цехэд нийлүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлэх.

Зорилт: 3.3.2.

- Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд шинээр нэвтрүүлж малын хаврын амьдын жинг 3-5 хувиар нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

3.3.2.1. Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх.

3.3.2.2. Олдохын хүрэн бор тэмээний тоог өсгөх замаар сумдад сайжруулагчаар ашиглах.

3.3.2.3. Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд омгоор баталгаажсан Өндөршил адуу, Сайнцагаан хонины үрийг хадгалах.

3.3.2.4. Аймгийн хэмжээнд үхэр сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэх.

3.3.2.5. Баянжаргалан сумын үхэр сүргийг "Дорнод монголын мухар улаан" үүлдрээр сайжруулах.

3.3.2.6. Аймгийн тэмээ өсгөх бодлогыг хэрэгжүүлж бойжуулсан ботго тутамд урамшуулал олгох системийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.

3.3.2.7. Жилд 20-оос доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах.

3.3.2.8. Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах.

Зорилт: 3.3.3.

- Нийт 7.4 сая га бэлчээрийн талбайн 70 хувьд бэлчээрийн даац 3 дахин илүү хэтрэлттэй байгаагийн 26 га талбайг 2024 он гэхэд нөхөн сэргээнэ.

Арга хэмжээ:

3.3.3.1. Олон дахин хэтэрсэн болон талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөх, сэлгэх, нөхөн сэргээх.

3.3.3.2. Дэрэн суман дахь тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж аймгийн тэжээлийн нөөцийн 60-аас доошгүй хувийг үйлдвэрлэх.

3.3.3.3. Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх.

3.3.3.4. Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд

халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах.

3.3.3.5. Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худагаар усжуулж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах.

Зорилт: 3.3.4.

- 2020 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 650 мянган толгой мал хамруулсныг 2024 онд 200 мянган толгой мал болгож вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 3.3.4.1. Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгох
- 3.3.4.2. Мал эмнэлгийн байгууллагыг гадна хашаа, автомашины гражтай болгох.
- 3.3.4.3. Сум бүрийг вакцин хадгалах хөргүүр, багуудыг мал угаалгын ванн, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг ажил, үйлчилгээ үзүүлэх хашаатай болгох.

3.4 Аялал жуулчлал

Зорилт:

- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад жуулчдын тоог 26000-д хүргэнэ.

Арга хэмжээ:

- 3.4.1.1. Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээг нэмэгдүүлэх.
- 3.4.1.2. Жуулчдын голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий Дэл уул зэрэг газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах.
- 3.4.1.3. Сүм хөх бүрд зэрэг аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлэх.
- 3.4.1.4. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи гэх зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчлах.
- 3.4.1.5. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах.
- 3.4.1.6. Жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төвийг байгуулах.
- 3.4.1.7. Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг салбарын ажилтнууд болон иргэдийг хамруулж боловсон хүчнийг бэлтгэх.

- 3.4.1.8. Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэх.
- 3.4.1.9. Аялал жуулчлалын бүс нутгуудад менежментийг сайжруулах.
- 3.4.1.10. Өлзийт, Гурвансайхан сумдад аялал жуулчлалын цогцолбор байгуулах.

3.5 Эрчим хүч

Зорилт: 3.5.1

- Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дэд бүтэц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр хангана.

Арга хэмжээ:

- 3.5.1.1. Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчилж, ашиглалтад оруулах.
- 3.5.1.2. Аймгийн төвийн дулааны станцын ажлыг эхлүүлэх.
- 3.5.1.3. Аймгийн төвийн 2-р хэлхээний шугам сүлжээний ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.
- 3.5.1.4. Эрчим хүч хэмнэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хөрөнгийг шийдвэрлэх.
- 3.5.1.5. Аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын цахилгаан эх үүсгэвэр холбох 220/110/35кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулах.
- 3.5.1.6. Аймгийн төвийн шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдын төвийн цахилгааны хангамжийг сайжруулах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

3.6 Тээвэр, логистик

Зорилт: 3.6

- Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2024 онд 5386.1 сая төгрөгт хүргэнэ.

Арга хэмжээ:

- 3.6.1.1. Аймгийн төвд ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих томоохон терминал логистикийн төв байгуулах.
- 3.6.1.2. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах.
- 3.6.1.3. Мандалговь-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу үүрэн телефоны сүлжээ бий болгох.
- 3.6.1.4. Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын

чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Зорилго:

- Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 65.8 хувьтай байгааг 2024 онд 73.8 хувьтай болгож нэмэгдүүлнэ.

4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ

Зорилт :4.1.1

- Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 4.1.1.1. "Цахим төр- Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
- 4.1.1.2. Сумдыг 4G сүлжээ, Алслагдсан багуудыг үүрэн телефоны сүлжээтэй болгох.
- 4.1.1.3. Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг сар бүр зохион байгуулах.
- 4.1.1.4. Төрийн архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
- 4.1.1.5. Төрийн архивыг нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.
- 4.1.1.6. Багийн Засаг дарга, малын эмч, байгаль хамгаалагч нарыг үе шаттайгаар унаажуулах.
- 4.1.1.7. Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ" систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгах.

4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

Зорилго:

- Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна.

Зорилт: 4.2.1

- Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна.

Арга хэмжээ:

4.2.1.1. Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх.

4.2.1.2. Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах.

4.2.1.3. Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, тэдний сурч мэдсэн зүйлийг аймагтаа хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.

Зорилт: 4.2.2

- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.

Арга хэмжээ:

4.2.2.1. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх.

4.2.2.2. Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.

Зорилт: 4.2.3

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.2.3.1. Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах.

4.2.3.2. Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн тусалцаа, үйлчилгээ үзүүлэх.

4.2.3.3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах.

4.2.3.4. Орон нутгийн ИНБ-уудын оролцоо хамтын ажиллагаанд тулгуурлан жендэрийн боловсрол олгох, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, аяныг гэрээлэн гүйцэтгүүлэх.

4.3 Амар тайван, аюулгүй нийгэм

Зорилго:

- Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2019 онд 86.5 байсныг 2024 онд 90-ээс дээш хувьд хүргэнэ.

Зорилт: 4.3.1

- Гэмт хэргийн гаралт 2019 онд 211 байсныг 2024 онд 10-аас доошгүй хувиар бууруулна.

Арга хэмжээ:

4.3.1.1. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулан, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

4.3.1.2. Цагдаагийн газрын хуучин барилгыг засварлаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төвийг байгуулж ажиллуулах.

4.3.1.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.

4.3.1.4. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачилга, оролцоотой томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх.

4.3.1.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах.

Зорилт: 4.3.2

- Гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 49.4 хувьтай байсныг 2024 онд 55-аас дээш хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.2.1. Аймгийн Цагдаагийн газрын автопарк болон алба хаагчдын 25-аас доошгүй хувийн хэт богино долгионы радио холбоог шинэчилж, албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.

4.3.2.3. Аймгийн Шүүхийн шинжилгээний албыг барилгатай болгож, мэргэжлийн лабораторыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

4.3.2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд телекамер бүхий димапон систем нэвтрүүлэх.

4.3.2.5. Аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байрыг сайжруулж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг бүрдүүлэн хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх.

4.3.2.6. Аймгийн Шүүхийн барилга шинээр ашиглалтад оруулах.

Зорилт: 4.3.3

- Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 4.3.3.1. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангах.
- 4.3.3.2. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтанд орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах.
- 4.3.3.3. Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах.
- 4.3.3.4. Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслээр хангах.

4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого

Зорилт: 4.4.1

- БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 онд 500 сая төгрөг байсныг 2024 онд 900 сая.төгрөгт хүргэнэ.

Арга хэмжээ:

- 4.4.1.1. БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай гадаад хамтын ажиллагааны хүрээнд тусгасан ажлуудыг шат дараалалтайгаар зохион байгуулах.
- 4.4.1.2. БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуяанг хоттой байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг ханган жилд 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах.
- 4.4.1.3. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулах.
- 4.4.1.4. Улаанбаатар хот дахь ОШУСТ-тэй хамтран жил бүр ОХУ-ийн ЗГ-ын тэтгэлэгт Хөтөлбөрт багш, сурагчдыг хамруулан ажиллах.

4.5 Батлан хамгаалах

Зорилт: 4.5.1

- Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамж 2020 онд 80 хувь байсныг 2024 онд 88 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 4.5.1.1. Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчилан таниулах.
- 4.5.1.2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын

- тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилэн нөөцийг бүрдүүлэх.
- 4.5.1.3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах.
- 4.5.1.4. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах.

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Ногоон хөгжил

Зорилго:

- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт: 5.1.1

- Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 2024 он гэхэд 4 хувиар бууруулна.

Арга хэмжээ:

- 5.1.1.1 Агаарт агуулагдаж байгаа тоос тоосонцорыг хэмжих зөөврийн багажтай болж, 3 төрлийн бодисыг бүрэн хэмждэг болох.
- 5.1.1.2 Утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх.
- 5.1.1.3 Төв суурин газрын гэр хорооллын сайжруулсан зуухны тоог нэмэгдүүлэх.
- 5.1.1.4 Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд шинэ дэвшилтэд техник, технологи /шахмал түлш/ нэвтрүүлэх аж ахуйн нэгжийг дэмжих.
- 5.1.1.5 Гэр хороолол болон аялал жуулчлал, уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлэх.

Зорилт: 5.1.2

- "Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2024 он гэхэд 46 тонн дахивар хогийг нийлүүлнэ."

Арга хэмжээ:

- 5.1.2.1 Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах.
- 5.1.2.2 Аймгийн төвд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх.

Зорилт: 5.1.3

- Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 26.5 байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

- 5.1.3.1 Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах.

5.1.3.2. Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

5.1.3.3. Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах.

5.1.3.4. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах.

Зорилт: 5.1.4

- Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 413.4 га-д хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.4.1. Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгох.

5.1.4.2. Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах.

Зорилт: 5.1.5

- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.5.1. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэх.

5.1.5.2. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэх.

5.1.5.3. Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулах.

Зорилт: 5.1.6

- Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.6.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах.

5.1.6.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах.

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

Зорилго:

- Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцаар 2020 онд 108 өрхийг хангаснаас 2024 онд 208 өрхийг нэмж хамруулна.

Зорилт: 6.1.1

- Иргэдийн оролцоотой "Шинэ сум" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд бүтэцтэй сум 2020 онд 2 байсныг 2024 онд 3-аар нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 6.1.1.1. Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах.
- 6.1.1.2. Сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох.
- 6.1.1.3. Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ажлын зургийг батлуулах.
- 6.1.1.4. Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.
- 6.1.1.5. Эрдэнэдалай сумын 2 км хатуу хучилттай авто зам, гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах.
- 6.1.1.6. Сумдад орон сууцны барилгыг ашиглалтад оруулах.
- 6.1.1.7. Сайнцагаан, Дэрэн, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах.
- 6.1.1.8. "Аймаг, сумын төвийн бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн төслөөр хэрэгжих 5 /цэвэр усны шугам, цэвэршүүлэх, авто зам, гэрэлтүүлэг, 2-р цэцэрлэг, гадна бохир усны шугам/ төсөл арга хэмжээний ажлын хөрөнгийг шийдвэрлэх.
- 6.1.1.9. Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх.
- 6.1.1.10. Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэжлүүлэх.
- 6.1.1.11. Сумдын өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлэх.
- 6.1.1.12. Цагаандэлгэр сумын ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах.
- 6.1.1.13. Дэлгэрхангай уулын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэх.

Зорилт: 6.1.2

- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо 2020 онд 3878 байсныг 2024 онд 4750 болгон нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

- 6.1.2.1 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх.
- 6.1.2.2 Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron.nутаg.mn сайтад тухай бүр мэдээлэх.